ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2026 ОНЫ 06 САРЫН 02-НЫ ӨДРИЙН
05 ДУГААР АЛБАН ДААЛГАВРЫН
ХҮРЭЭНД 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2026 оны 06 дугаар сарын 08 Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | |
| **Зорилт 1.** Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлага ёс зүй, дүрэм, журмын хэрэгжилтийг сайжруулах | | | | | |
| 1.1 | Байгууллагын хэмжээнд ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг үнэлэх, Эрүүл мэндийн ажилтны ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж, үйлчлүүлэгчтэй зөв боловсон, хүндэтгэлтэй харицах соёлыг хэвшүүлэх | - | Хамруулсан ажилчдын тоо | 2026 оны хагас жилийн байдлаар СХДЭМТ-ийн эмч, ажилтнууд дунд Ёс зүй харилцаа хандлагыг сайжруулах, ёс зүйн зөрчилд өртөх эрсдлээс сэргийлэх чиглэлээр нийт 10 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 379 ажилтныг хамруулсан.<br>1. Байгууллагын дотоод харилцааг сайжруулах, удирдах ажилтнуудын харилцааны ур чадварыг хөгжүүлэх, харилцаанд илэрч буй зан төлөвийн ялгааг ойлгон, зөв хандлага төлөвшүүлэх зорилгоор Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн тасаг, нэгжийн эрхлэгч, арга зүйч нарт **“Харилцан адилгүй зан төлвийг удирдах нь”** сэдэвт сургалтыг 2026 оны 02 дугаар сарын 13- ний өдөр Захиргаа, хүний нөөцийн албаны дарга Ц.Одонтуяа хичээлийг зааж, сургалтад тасгийн эрхлэгч, арга зүйч сувилагч нийт 13 ажилтан хамрагдсан.<br> | 80% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | |  <br>2. Байгууллагын дотоод харилцааг сайжруулах, удирдах ажилтнуудын харилцааны ур чадварыг хөгжүүлэх, харилцаанд илэрч буй зан төлөвийн ялгааг ойлгон, зөв хандлага төлөвшүүлэх зорилгоор Баянхошуу салбар амбулаторийн эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 2026 оны 02 дугаар сарын 27,28 өдрүүдэд **“Харилцан адилгүй зан төлөв”** сэдэвт сургалтыг Захиргаа, хүний нөөцийн албаны дарга Ц.Одонтуяа хичээлийг зааж, сургалтад 40 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамруулсан.<br> <br>3. Сонгинохайрхан дүүргийн Насан Туршийн Суралцахуйн төвтэй хамтран Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнуудад **“Харилцаа хандлага”** сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 87 эмч, ажилтнуудыг хамруулсан.<br>  | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | |  <br>4. ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны дарга Д.Оюунбилэгтэй /АУ-ны доктор, дэд профессор/ хамтран **“Эрүүл мэндийн байгууллагын соёлд ёс зүй, үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх нь”** сэдэвт 2 кредит сургалтыг 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж 33 эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, ажилтнуудыг хамруулсан.<br> <br>5. Хамт олны дотоод харилцаа, ажилтан хоорондын ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэх зорилгоор 2026 оны 02 дугаар сарын 09 ний өдөр **“Зөв харилцаа хандлага”** сэдвээр “Эерэг бүхний лектор” Д.Шинэбаярыг урин сургалтыг зохион байгуулж 58 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан.<br>  | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | |   6. Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн удирдах албан тушаалтнууд Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн авлигын эсрэг хууль тогтоомжийн мэдлэгийг нэмэгдүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, зөв хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар М.Жамьянчойжилтой **хамтран "Авлигын гэмт хэргийн нийгмийн хор аюул, хор уршгийг таниулах"** сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. Сургалтанд Эрүүл мэндийн төвийн 33 удирдах албан тушаалтан, арга зүйч нар Өрхийн эрүүл мэндийн төвийн 48 дарга, ахлах сувилагч нийт 81 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан.<br><br>  7. Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, албан хаагчид **"Эмнэлгийн мэргэжилтний хууль эрх зүйн мэдлэг"** сэдвээр 2026 оны 04 дүгээр сарын 24 өдөр Сургалтыг Цагдаагийн Ерөнхий газрын Хүний эрх, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Д.Амартүвшин, ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад С.Шинэбаяр нар сургалтыг зохион байгуулж Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх гэмт хэргийн ойлголт, хуулийн тайлбар, хуулийн хариуцлага, анхаарах асуудлын талаар нийт 32 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, албан хаагчдад мэдээлэл хүргэсэн. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | |  <br>8. Авлигатай Тэмцэх Газараас 2026 оны 03 дугаар сарын 13 ний өдөр зохион байгуулсан **“Авлигаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин” сэдэвт цахим сургалтад** Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн 10 удирдах албан тушаалтнууд хамруулсан. Сургалтаар авлига үүсэх түгээмэл шалтгаан, авлигын илрэх хэлбэрүүд, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгч, мэдлэг олгосон.<br><br>9. Тасгийн эмч сувилагч, үйлчлэгч нарын Харилцаа, хандлага, ёс зүйн талаарх мэдлэгийг сайжруулах зорилгоор “Ёс зүй, харилцаа хандлага” сэдвээр Мэс засал, гэмтлийн тасаг дотооддоо 2026 оны 02 дугаар сарын 06 ний өдөр сургалт зохион байгуулж тасгийн 13 ажилтныг хамруулсан. сургалт явууллаа.<br>10. Оношзүйн тасаг ажилтнуудынхаа ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм" сэдвээр дотоод сургалтыг 2026 оны 04 дүгээр сарын 07 ний өдөр зохион байгуулэ тасгийн 12 эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.<br> | |

<table>
<tr><td></td><td></td><td>-</td><td>Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо</td><td>2026 оны хагас жилийн байдлаар:<br>1. СХДЗДТГ-аас зохион байгуулсан Бид авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон аяныг 2026 оны 05 дугаар сарын 01 ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 10-нийг хүртэл байгууллагын хэмжээнд өрнүүлэн, арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна. Аяны хүрээнд:<br>➢ Баянхошуу салбар болон төв салбар дээр авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар нээлттэй хаалганы өдөрлөг,<br>➢ Хамт олныг аянд уриалсан уриалга, арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна.<br><br>2. Ёс зүйн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Дотрын өвчин судлалын I, II тасаг "Ёс зүйн тушаал, дүрмийг хэн сайн мэдэх вэ?" АХА тэмцээнийг 2026 оны 05 дугаар сарын 08 ний өдөр тасгийн эмч сувилагч асрагч нарын дунд зохион байгуулж, ажилтнуудынхаа мэдлэгийг үнэлж шагнаж, урамшуулсан. Үүнд:<br>➢ Сувилагч Х.Түвшинжаргал 1 байр<br>➢ Сувилагч Д.Энхтунгалаг 2-р байр<br>➢ Сувилагч Э.Тэсээнлхам 3-р байрыг тус тус эзлэн амжилттай оролцсон.</td><td>70%</td></tr>
</table>

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | <br>3. Тасаг нэгж бүрд үйлчлүүлэгчдэд болон ажилтнуудад зориулсан ёс зүйн булангуудыг гарган мэдээ, мэдээллүүдийг тогтмол шинэчлэн, мэдээллийг ил тод нээлттэйгээр хүргэн ажиллаж байна.<br><br><br>4. Ёс зүй харилцаа хандлагыг сайжруулах, ёс зүйн зөрчилд өртөх эрсдлээс сэргийлэх 4 зөвлөмж, Авлигын эрсдэлээс ангид байхыг уриалсан 2 постер, мэдээллүүдийг бэлтгэн Эрүүл мэндийн төвийн албан ёсны цахим хуудас болон СХДЭМТ-ийн ажилтнуудын групп | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хуудсанд байршуулан түгээсэн  давхардсан тоогоор нийт 4741 хүнд хүрч, 25 хүнд таалагдаж, 6 хүн хуваалцан байна.<br>  <br> <br>5. Бид авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон аяны хүрээнд СХДЭМТ тасаг нэгжүүд болон ӨЭМТ-үүд4 бүс ШУДАРГА, СОЁЛТОЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ" сэдэвт иргэд болон ажилтнуудыг авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хиймэл оюун ухаанд (AI) суурилсан богино хэмжээний видео контентыг түгээмэл тохиолддог кейсээр нийт 6 рийл зөвлөмжийг боловсруулж, байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажилласан 15106 хүнд хүрч, 160 хүнд таалагдаж, 42 хүн хуваалцан байна. Авлигатай тэмцэх газрын гарын авлагыг ажилтнууд болон иргэдэд  тараан мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.<br>   | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | |  | |
| 1.2 | Эрүүл мэндийн байгууллага өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах утас, цахим хаягийг олон нийтэд ил тод байршуулах | - | Байршуулсан мэдээллийн тоо | 2 | 50% |
| | | | Хандалтын, тоо | 1100 | |
| 1.3 | Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, ажилтнуудын харилцаа, ёс зүйтэй холбоотой асуудлаар иргэд, байгууллагаас төрийн бүх шатны байгууллагад тавьсан өргөдөл, гомдол, санал хүсэлт, сошиал хуудсанд байршсан асуудлыг шуурхай шийдвэрлэж, үнэн зөв хариу мэдээлэл өгөх | - | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн тоо | 2026 оны хагас жилийн байдлаар нийт 131 өргөдөл гомдол санал хүсэлт талархал ирсэн байна. Үүний СХДЭМТ-д 70, ӨЭМТ-61 өргөдөл гомдол талархал санал хүсэлтийг авсан байна.<br>Талархал-76<br>Гомдол-48<br>Санал-1<br>Хүсэлт-6<br>Өргөдөл, гомдлыг **шийдвэрлэх дундаж хугацаа – 21 цагийн дотор 100% шийдвэрлэсэн** байна<br><br> | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| ***Зорилт*-2.** Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, иргэн төвтэй үйлчилгээ үзүүлэх чиглэлээр: | | | | | |
| 2.1 | Эмнэлгийн туслмаж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр нийт ажилтнуудад мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, эрсдэлийг эрт илрүүлэх, мэдээлэх, буруутгах бус суралцах, тасралтгүй сайжруулах соёлыг төлөвшүүлэх сургалт, идэвхжүүлэх ажлыг зохион байгуулах | ЭМТ | Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр нийт ажилтнуудад мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, эрсдэлийг эрт илрүүлэх, мэдээлэх, буруутгах бус суралцах, тасралтгүй сайжруулах соёлыг төлөвшүүлэх сургалтыг нийт 11 удаагийн сургалт зохион байгуулж 197 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. | 100% |
| | | | Сургалтанд хамрагдсан хүний тоо | 1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, чанар аюулгүй байдлын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд шинээр ажилд томилогдсон ажилтнуудад чиглэсэн сургалт, мэдээллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулсан. 2026 оны 01, 02, 04, 05 дугаар саруудад нийт 4 удаагийн "Шинэ ажилтныг чиглүүлэх" сургалт зохион байгуулж, нийт 37 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг хамруулсан байна.<br>2. Байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог ISO 9001:2015 стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулах, эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн чанарын менежментийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаанд стандартын шаардлагыг зөв хэрэгжүүлэх ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад нийт 42 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдав.<br>3. 2026 оны 02-р сарын 13-14-ний өдрүүдэд Амбулаторийн тасагт Яаралтай тусламжийн бэлэн байдалд хяналт үнэлгээ хийсэнтэй холбогдуулан доорх сэдвээр удирдамж, хуваарь гарган 2 удаа нийт 58 эмч, сувилагч, эмнэлгийн ажилчдад ЯТЭЭТ-тай хамтран дотоодын сургалтыг зохион байгууллаа. Сургагч эмч багш ЯТЭЭТ-ийн эрхлэгч Долгорсүрэн, аргазүйч Наранцэцэг нар ажилласан.<br>4. Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд "Үйлчлүүлэгчийг аюулгүй гадна, дотор тээвэрлэх сургалтыг тасаг бүрд ЭМТҮЧАБА-ны дарга, Чанарын менежер, Эрсдэлийн менежер очиж тасгийн бүх эмч, сувилагч, асрагчийг хамруулан тохиолдол, кейс ажиллуулсны дараа сургалтыг орж, тээвэрлэлтийн үед гаргасан алдсан, чадахгүй, мэдэхгүй байгаа асуудлыг ярилцаж, бие биеэсээ | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | суралцсан сургалт болсон. Нийт 25 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>5. СХДЭМТ-д ISO MNS 9001:2016 стандартыг хэрэгжүүлж эхлэхтэй холбоотой эрсдэлийн сан үүсгэх, ажилтан бүр эрсдэл, тохиолдлыг мэдээлэх, бүртгэх, хариу арга хэмжээг мэддэг байх зорилгоор эмнэлгийн хэмжээнд эрсдэл, тохиолдол бүртгэх QR кодыг нэвтрүүлэн тасгийн нийт 6 арга зүйч нарт танилцуулсан сургалт орсон.<br>6. Чанарын багуудын үйл ажиллагааг дэмжиж чадавхижуулах нь" сэдэвт сургалтыг 2026 оны 02 дугээр сарын 13-ний өдөр нийт 29 эмнэлгийн ажилтаныг хамруулан зохион байгуулсан. | |
| 2.2 | Яаралтай тусламжийг харьяалал харгалзахгүйгээр иргэдэд чирэгдэлгүй үзүүлэх | - | Үйлчлүүлэгчийн тоо | Яаралтай тусламж үйлчилгээг иргэдэд харьяалал харгалзахгүйгээр түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж ажилласан. Тусламж үйлчилгээ авах иргэдийг бүртгэл, харьяаллын асуудлаар чирэгдүүлэхгүйгээр шаардлагатай эмнэлгийн тусламжийг цаг алдалгүй үзүүлж, өвчтөний аюулгүй байдлыг хангаж ажилласан. 2026 оны 05 сарын байдлаар яаралтай тусламжийн тасгаар нийт 4826 иргэн үйлчлүүлснээс 1301 иргэн хэвтэн эмчлүүлсэн 3525 иргэн тусламж үйлчилгээ аваад буцсан байна. ЯТЭЭТ-аар ирсэн үйлчлүүлэгч бүрт яаралтай тусламжийн хуудас нээж, эрэмблэн ангилж эмнэлгийн тусламж үйзүүлдэг. Яаралтай тусламжийн бэлэн байдлыг тогтмол хангаж, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хариуцлагыг сайжруулан, иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан. Үүний үр дүнд яаралтай тусламж үйлчилгээний тасралтгүй байдал хангагдаж, иргэд шаардлагатай тусламжийг хүндрэл, чирэгдэлгүйгээр авах нөхцөл бүрдсэн. | 100% |
| 2.3 | "Үйлчлүүлэгчийг дэмжих алба"-г Сувилахын албаны дэргэд байгуулж, чиг үүргийг тодорхойлж, удирдлага арга зүйгээр хангах | ЭМТ | Үйлчлүүлэгчийг дэмжих алба хүний нөөц, тоног төхөөрөмжийн судалгааг гаргах<br>Үйлчлүүлэгчийг дэмжих албыг байгуулах | Эрүүл мэндийн төвийн даргын 2026 оны 01 дүгээр тушаалаар "Үйлчлүүлэгчийн дэмжих алба"-ыг 5 ажилтны бүрэлдэхүүнтэй ажиллуулахаар орон тоог баталсан. | 30% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2.4 | Эмнэлэг хооронд эмчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох, хүлээлгэн өгөх үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулах, эмнэлгийн тусламжийн тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн эмнэлэг доторх тасаг нэгжийн үйл ажиллагааны уялдааг хангах | - | Шилжүүлсэн үйлчлүүлэгчийн тоо | Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын А/32 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах ажиллах журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж, эмчлүүлэгчийг шатлал хооронд аюулгүй шилжүүлэх, мэдээлэл солилцох, хүлээлгэн өгөх үйл ажиллагааны дагуу нийт 119 үйлчлүүлэгчийг эмнэлэг хооронд шилжүүлсэн.<br>Мөн эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах хүрээнд байгууллагын дотоодод нийт 39 үйлчлүүлэгчийг тасаг хооронд шилжүүлэн эмчилгээ, оношилгоог үргэлжлүүлсэн. Үүнээс Яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгаас бусад тасгуудад 35 үйлчлүүлэгч, Сэхээн амьдруулах тасгаас 4 үйлчлүүлэгчийг шилжүүлэн хүлээлгэн өгч, шаардлагатай эмчилгээ, сувилгааг тасралтгүй үзүүлсэн. | 50% |
| Зорилт 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настанд үзүүлэх тусламжийг чирэгдэлгүй болгох | | | | | |
| 3.1 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настнуудад эмнэлгийн тусламж үйлчилгээг дараалал харгалзахгүй, түргэн шуурхай үзүүлэх орчин нөхцөл, зохион байгуулалтыг бүрдүүлэх | - | Цахим дугаар олголт<br>Эмчилгээ үйлчилгээнд хамрагдсан хүний тоо | Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн А/90 тоот захирамжаар хөгжлийн бэрхшээлтэй зорилтот бүлэгт чиглэсэн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж байна. 2026 оны 2-р сарын 5-наас 13-ны өдрүүдэд Өрхийн эрүүл мэндийн төвүүд нийт 418 ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзлэг, оношлогоог хооронд хийж ажилласан.<br>Үзлэгээр:<br>1. Цусны ерөнхий шинжилгээ<br>2. Шээсний ерөнхий шинжилгээ<br>3. Захын цусанд глюкоз хэмжих<br>4. Элэгний В,С вирусын маркер тодорхойлох<br>5. Хэвлийн ЭХО<br>6. Зүрхний цахилгаан бичлэг<br>7. Биоэнергийн аппарат ашиглан оношилгоо, шинжилгээ хийж шаардлагатай иргэдэд гэрийн эмчилгээ, дархлаа дэмжих бүтээгдэхүүнүүдийг тараалаа.<br>Мөн хэвтрийн ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асран хамгаалагч нарт асаргаа зөвлөгөө болон хөнгөвчлөх тусламж үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | 80% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | |   | |
| 3.2 | Эмнэлгийн ажилтан, албан хаагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах | - | Зохион байгуулсан сургалтын тоо | Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12-р сарын 17-ны өдрийн A/512 тоот тушаалыг хэрэгжүүлэн сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцсэн тусламж үйлчилгээ үзүүлэх мөн Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлэн сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй тусламж үйлчилгээ үзүүлэх, эмч, ажилчдыг чадавхжуулах зорилгоор "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд Ахмад мэргэжилтэн Б.Дуламжав багштай хамтран "ДАКТИЛЬ ЦАГААН ТОЛГОЙ, ДОХИОНЫ ХЭЛ"-ний сургалтыг 2026 оны 4 сарын 6-наас эхлэн сургалтын үйл явц үргэлжилж байна.<br>Сонсголын бэрхшээлтэй үйлчлүүлэгчид хүрч үйлчлэх, хүртээмжтэй байх үүднээс лавлагаа мэдээллийн менежер, эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан, эрүүл мэндийн нийгмийн ажилтан, хувцас олгогч, арга зүйч , даатгалын тасгийн эмч, мэдрэлийн өвчин судлалын сувилагч нарыг сургалтанд хамруулсан бөгөөд нийт 15 эмнэлгийн ажилтан сургалтанд хамрагдаж байна.<br>  | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4. Эмнэлгийн гадаад, дотоод орчин аюулгүй байдлыг хангах** | | | | | |
| 4.1 | Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг хангах, хүртээмжийн хялбаршуулсан үнэлгээ, аюулгүй байдлын үзлэг хийж, илэрсэн зөрчлийг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | - | Хэрэгжилтийн хувь | 2026 оны 6-р сарын 4-ны өдрийн 10 цагт гадна орчны болон амбулаторийн аюулгүй байдлыг үнэлэх хяналтын хуудсаар ЭМТҮЧАБА эрсдлийн менежер Д.Гантөмөр, Дотоод хяналтын албаны дарга Б.Мөнхжаргалын хамт үнэлгээ хийсэн. Дундаж үнэлгээ 100 оноо авах ёстойгоос 80 оноо буюу хангалттай гэж үнэлэгдсэн. Гадна орчны аюулгүй байдлыг үнэлэх хяналтын хуудсаар хийсэн үнэлгээний явцад дараах давуу талууд илэрсэн болно. Үүнд:<br>1. Гадаад орчноос эмнэлгийн хаалгаар орох өвчтөнд саад, тотгор болох зүйл үгүй, налуу шат яаралтай тусламж хэсэгт байрласан, аюулгүй байдлыг хангасан.<br>2. Үүдний хэсэгт тэргэнцэр байрлуулсан, хүлээлгийн өрөөний сандал хүрэлцээтэй.<br>3. Гадна орчинд олон хүн хүлээж суух сандал байрлуулсан.<br>4. Зүлэгжилт, орчны цэвэр байдал сайтар бүрдсэн.<br>**Илэрсэн сул талууд:**<br>**Эмнэлгийн гадаад орчинд**<br>1. Эмнэлгийн гадна орчны хаяг бүдэг, 10 м-н зайнаас харагдахгүй<br>2. Үүдэн хэсэгт тэргэнцэрийн арчилгаа муудсан, цэвэрлэх шаардлагатай, үүдний хэсгийн эмх цэгц тааруу<br>3. Гадна суух сандлын дэргэд сүүдрэвч байхгүй<br>4. Үүдээр орох шатны довжоо өвлийн зориулалттай наалт бүхий бохир<br>5. Цахилгааны утас гражны дэргэд унжиж байрласан бөгөөд хүүхэд хүрэхийг хориглоно тэмдэглэгээ тавих<br>**Эргэлтийн хэсэг**<br>1. 2-р давхарын гэрэлтүүлэг ажиллаагүй нь 19 цагаас хойш харанхуй болоход үзэгдэх орчин хязгаарлагдах аюултай<br>2. Эргэлтийн давхар бүрт үйлчлүүлэгчийн эргэлтийн журам нь жигд биш, янз бүрийн журамтай<br>3. Мэс заслын 7-р давхарт хүн орох шаардлагагүй бол гинжин хаалт байрлаагүй<br>4. Шатны плитанууд ховхорч унасан, хагарсан<br>**Амбулатори дотор хэсэг**<br>1. Амбулатори хэсэгт эмч нарын үзлэгийн кабинетуудын хаягжилт бүрэн хийгдэж дуусаагүй, жигд биш | 80% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 2. Дуугай хөтөч үйлчлүүлэгч нарт ойлгомж багатай харагдаж байна<br>Иймд дээрх зөрчлүүдийг анхаарах, засаж сайжруулахын тулд төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Дээрх илэрсэн сул талууд нь эмнэлгийн их засвартай холбоотой илэрсэн. Засварын ажил дуусаж улсын комисс хүлээн авсан тул илэрсэн зөрчлийг засахаар ажиллаж байна. | |
| 4.2 | Үйлчлүүлэгч эмнэлгийн дотор болон гадна орчинд унах, халтирах, бэртэж гэмтэх эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, эрсдэл бууруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх | | Хэрэгжилтийн хувь | Эмнэлгийн дотор болон гадна орчинд үйлчлүүлэгчийн унах, халтирах, бэртэж гэмтэх эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, илэрсэн эрсдэлд тулгуурлан эрсдэл бууруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажилласан. Төлөвлөсөн ажлын хэрэгжилт 60 хувьтай байна. Эрсдэлтэй хэсгүүдийг тодорхойлж, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, шалны халтиргаа үүсэхээс сэргийлэн цэвэрлэгээ үйлчилгээний хяналтыг сайжруулах, гадна орчны зам талбайн эвдрэл гэмтлийг засварлах, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Мөн ажилтан, үйлчлүүлэгчдэд аюулгүй байдлын талаар зөвлөмж мэдээлэл хүргэж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан. Цаашид үлдсэн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, орчны аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр тасралтгүй ажиллахаар байна. | 60% |
| 4.3 | Эрүүл мэндийн байгууллагын гадна талбайн орох гарах гарц болон чиглэлийн тэмдэг, тэмдэглэгээг тодорхой, саадгүй байлгах, гадаад орчинд тавигдах аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг тогтмол хангаж ажиллах | ЭМТ | Аюулгүй байдлын гарц, тэмдэг тэмдэглэгээ | Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв нь 2026 онд их засвар хийгдэж дууссан ба байгууллагын гадна талбайн орох гарах болон чиглэлийн тэмдэглэгээнүүдийг шинэчлэн байршуулж, гадаад орчинд тавигдах шаардлагыг хангаж шинээр хашлага хийсэн.<br> | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | |   | |
| 4.4 | Эмнэлгийн тасаг, нэгжүүдийн байршил, зүг чиг заасан хаяг тэмдэг тэмдэглэгээ, дуугүй хөтөчийг иргэдэд ойлгомжтой уншихад хялбар харагдахуйц байдлаар шинэчлэх | ЭМТ | Хаяг, тэмдэг тэмдэглэгээ<br>Дуугүй хөтөчийг байршуулсан эсэх | Эрүүл мэндийн төвийн засвар, тохижилтын ажил бүрэн дууссч, барилгыг улсын комисс албан ёсоор хүлээн авсан. Үүний дараагаар байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор урсгал засвар, дотоод зохион байгуулалтын ажлууд үе шаттайгаар үргэлжилж байна. Тухайлбал, үйлчлүүлэгч болон ажилтнуудад чиг баримжаа олгох чиглүүлэгч самбаруудын байрлал, мэдээллийн агуулгыг шинэчлэн сайжруулж, илүү ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар шинэчлэн байршуулж байна. Мөн үйлчлүүлэгчийн урсгалыг зөв зохион байгуулах, тасаг нэгжүүдийг хялбар таних нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дуугүй хөтөчийн тэмдэглэгээ, зааварчилгааг шинэчлэн суурилуулж байгаа       | 50% |

Тайланг нэгтгэсэн: ЗХНА-ны дарга Ц.Одонтуяа

## ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2026 ОНЫ 06 САРЫН 02-НЫ ӨДРИЙН 05 ДУГААР АЛБАН ДААЛГАВРЫН ХҮРЭЭНД ХАРЬЯА ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДЭД 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2026.06.08

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **Зорилт 1.** Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлага ёс зүй, дүрэм, журмын хэрэгжилтийг сайжруулах | | | | | |
| 1.1 | Байгууллагын хэмжээнд ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг үнэлэх, Эрүүл мэндийн ажилтны ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж, үйлчлүүлэгчтэй зөв боловсон, хүндэтгэлтэй харицах соёлыг хэвшүүлэх | - | Хамруулсан ажилчдын тоо | Хагас жилийн хугацаанд нийт ӨЭМТ давхардсан тоогоор 47 удаагийн ёс зүйн дотоод сургалт, 3 удаагийн төлбөртэй сургалт зохион байгуулж ажиллалаа. Сургалтанд хамрагдсан ажилтны тоо 458 байна. Мөн сар бүрийн ажилчдын гүйцэтгэлийн үнэлгээнд ёс зүй харьцаа хандлагыг тусгаж нийт ажилчидтай гэрээ байгуулан ажилласнаар 2026 оны эхний хагас жилийн байдлаар нотлогдсон ёс зүйн гомдол бүртгэгдээгүй байна.<br>Эмч, эмнэлгийн мэргэжилтэнг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх байдлаар 4 сэдвээр нийт 458 эмч эмнэлгийн мэргэжилтэн нарт эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн хэм хэмжээ, ажлын байрны зэрэг хандлага бий болгох, эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага, хэрхэн эрүүл мэндийн ажилтан болох вэ, эмч, эмнэлэгийн мэргэжилтэн гэж хэн бэ сэдэвт сургалтуудыг зохион байгуулан ажиллалаа.<br>Байгууллагын хөтөчийн хэсэгт санал хүсэлтийн дэвтэр болон санал хүсэлтийн хайрцагийг үйлчлүүлэгчдийн нүдэнд харагдахуйц газар | 100% |
| | | - | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | байрууулснаар дэвтэрээр талархал санал хүлээн авч байна. Мөн угтах хэсэг, өрөө бүрийн үүдэнд эмч нарын ширээ дээр иргэдийн сэтгэл ханамжийн асуумж авах QR кодыг ил байршуулж иргэний санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажиллалаа. Байгууллагын утасыг мэдээлэл бүрт тусгаж иргэдэд нээлттэй хүргэсэн. | |
| 1.2 | Эрүүл мэндийн байгууллага өргөдөл, гомдол санал хүсэлтийг хүлээн авах утас, цахим хаягийг олон нийтэд ил тод байршуулах | - | Байршуулсан мэдээллийн тоо<br>Хандалтын, тоо | ӨЭМТ – нь сэтгэл ханамжийн судалгаа дараах мэдээллийн сувгуудаар авч байна. Үүнд:<br>➢ Эрүүл мэндийн статистик мэдээллийн 1313.mn сайт руу QR – уншуулан авах<br>➢ Мөн засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 1111 төв, утас, биечлэн, фэйсбүүк, чат, дэвтэр, хайрцаг зэрэг нийт 6 төрлөөр үйлчлүүлэгчээс болон харилцагч байгууллагаас өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, хариу арга хэмжээг авч ажиллалаа. Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг авах мэдээллийг эмнэлгийн хүлээлгийн танхимд, эмч, сувилагч бүрийн ширээн дээр Qr – аар, байгууллагын цахим хаягт ил тод байршуулан ажиллалаа.<br>Төв нь үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судадалгааг сайтаар буюу Qr уншуулан сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэлээ. Үүнээс гадна төвийн ЭМТҮЧАБ багт ирсэн сэтгэл ханамжийг авч үзвэл:<br>➢ Санал хүсэлтийн хайрцагаар – 500 гаран<br>➢ Санал хүсэлтийн дэвтэрээр – 68<br>➢ Хэрэглэгчид үйлчлэх төв 11 – 11 -ээр – 61 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ➢ Байгууллагын утасаар – 15<br>➢ Талархлалын хуудсаар - 48 | |
| 1.3 | Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, ажилтнуудын харилцаа, ёс зүйтэй холбоотой асуудлаар иргэд, байгууллагаас төрийн бүх шатны байгууллагад тавьсан өргөдөл, гомдол, санал хүсэлт, социал хуудсанд байршсан асуудлыг шуурхай шийдвэрлэж, үнэн зөв хариу мэдээлэл өгөх | - | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн тоо | 2026 оны хагас жилийн байдлаар 61 иргэнээс 11-11 төвөөр дамжин 21 гомдол 29 талархал,1 хүсэлт ирсэн бөгөөд өргөдөл гомдолд дүгнэлт гаргаж, гомдол санал хүсэлтийн мөрөөр ӨЭМТ тус бүр ЭМТҮЧАБ багаар хэлэлцэж арга хэмжээ авч ажилласан. | 98% |
| **Зорилт-2.** Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, иргэн төвтэй үйлчилгээ үзүүлэх чиглэлээр: | | | | | |
| 2.1 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр нийт ажилтнуудад мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, эрсдэлийг эрт илрүүлэх, мэдээлэх, буруутгах бус суралцах, тасралтгүй сайжруулах соёлыг төлөвшүүлэх сургалт, идэвхжүүлэх ажлыг зохион байгуулах | ЭМТ | Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо<br>Сургалтанд хамрагдсан хүний тоо | ЭМТҮЧАБ баг нь дотоод сургалтын графикийг гарган батлуулж хагас жилийн байдлаар өрх тус бүр дотооддоо 2 удаагийн сургалт зохион байгуулж ажиллалаа.<br>Дотоод сургалтын ирцийн хамрагдалт нийт 458 ажилтан хамрагдаж, хамрагдалт 84.3% байна. | 92% |
| 2.2 | Яаралтай тусламжийг харьяалал харгалзахгүйгээр иргэдэд чирэгдэлгүй үзүүлэх | - | Үйлчлүүлэгчийн тоо | Яаралтай тусламжийг ЭМС-ын А\814,А\489 ЭМС-ын А\220 тоот тушаалын дагуу үзүүлж ажиллаааг ба журмыг ӨЭМТ-ийн хэмжээнд боловсруулан баталсан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 50% |
| 2.3 | "Үйлчлүүлэгчийг дэмжих алба"-г Сувилахын албаны дэргэд байгуулж, чиг үүргийг тодорхойлж, удирдлага арга зүйгээр хангах | ЭМТ | Үйлчлүүлэгчийг дэмжих алба хүний нөөц, тоног төхөөрөмжи | Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагаа MNS5292:2017 стандартад заагдсан бүтэц орон тоо, хүний нөөцийн хангалт 100%, зайлшгүй шаардлагатай эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн хангалт - 94% - тай. | 77,5% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | йн судалгаа гаргах<br>Үйлчлүүлэгчийг дэмжих албыг байгуулах | Төвүүд одоогоор үйлчлүүлэгчийг дэмжих алба байгуулаагүй байна. Харин төвийн сувилахуйн баг үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. | |
| 2.4 | Эмнэлэг хооронд эмчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох, хүлээлгэн өгөх үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулах, эмнэлгийн тусламжийн тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн эмнэлэг доторх тасаг нэгжийн үйл ажиллагааны уялдааг хангах | - | Шилжүүлсэн үйлчлүүлэгчийн тоо | ЭМС-ын А\220 тоот тушаалын хэрэгжилтийг хангаж ажилладаг ба өвчтөн тээвэрлэх журмыг ӨЭМТ-ийн хэмжээнд боловсруулан баталсан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар яаралтай тээвэрлэх шаардлагатай тохиолдол бүртгэгдээгүй байна. Тээвэрлэлтийн бэлэн байдалд үнэлгээ хийхэд зөөврийн монитор, хүчилтөрөгчийн зөөврийн баллон, шаардлагатай эм тариа, бусад хэрэгслийн хангалт 95% байна.СХДЭМТ – ийн хүүхдийн болон нөхөн үржихүйн зохицуулагч эмч нараар дүүрэг болон орон нутагт шилжүүлэн ажиллалаа. | 100% |
| **Зорилт 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настанд үзүүлэх тусламжийг чирэгдэлгүй болгох** | | | | | |
| 3.1 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настнуудад эмнэлгийн тусламж үйлчилгээг дараалал харгалзахгүй, түргэн шуурхай үзүүлэх орчин нөхцөл, зохион байгуулалтыг бүрдүүлэх | - | Цахим дугаар олголт<br>Эмчилгээ үйлчилгээнд хамрагдсан хүний тоо | Төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд АндМед ХХК программыг нэвтрүүлэн үйлчлүүлэгчдэд тусламж үйлчилгээ авах дараалал дугаарыг цаг сонгон авах боломжоор хангаж ажиллаж байна.<br>Эмч, сувилагчийн хяналтанд байгаа нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хяналтандаа авч гэрийн идэвхитэй эргэлтийн хувь 85 % - д сувилахуйн тусламж үйлчилгээ, биеийн бүтэн болон хэсэгчилсэн угаалга, амны хөндийн угаалга, толгой угаах, 3,4 – р зэргийн холголт, цооролттой шархыг цэгцлэх, цэвэрлэх боолт хийх, асран хамгаалагч нарт эрүүл мэндийн болон, асаргаа сувилгааны талаар зөвлөгөө мэдээлэл өгөх, мөн эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээнээс гэрийн эмчилгээнд хамруулж ажиллав.<br>Хөгжлийн бэрхшээлтэй гаруй иргэд болон ахмад | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | настнуудад эмнэлгийн тусламж үйлчилгээг дараалал харгалзахгүй, түргэн шуурхай үзүүлэх орчин нөхцөл, зохион байгуулалтыг бүрдүүлэхххүрээнд хөтөч сувилагчид чиг үүрэг өгч ажилласнаар нийт ХБИ иргэдийг дараалал харгалзахгүй үйлчилгээнд хамруулсан байна. Мөн гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан нийт ахмад хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулсан бол гэрийн эргэлтэд нийт хөгжлийн бэрхшээлтэй ахмад настныг нийт 85 хувь хамруулж тусламж үйлчилгээ үзүүлсэн. | |
| 3.2 | Эмнэлгийн ажилтан, албан хаагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах | - | Зохион байгуулсан сургалтын тоо | СХД – ийн "Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс" – ээс зохион байгуулсан нийгмийн ажилтнуудыг хүүхэд хамгааллын чиглэлээр чадавхижуулах, Аутизмтай хүүхэдтэй хэрхэн зөв харилцах зэрэг сургалтыг зохион байгуулж ажилласан байна.<br>Эмнэлгийн ажилчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 2026 оны 3р улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах Зайнаас зөвлөн туслах төвийн хаяг мэдээлэл холбоо барих холбоосыг эмнэлгийн хөтөч хэсэгт байршуулан тогтмол ашигладаг. | 100% |
| **Зорилт 4.** Эмнэлгийн гадаад, дотоод орчин аюулгүй байдлыг хангах | | | | | |
| 4.1 | Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг хангах, хүртээмжийн хялбаршуулсан үнэлгээ, аюулгүй байдлын үзлэг хийж, илэрсэн зөрчлийг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | - | Хэрэгжилтийн хувь | Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг хангах төлөвлөгөө гарган төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган эмнэлгийн цагийн хуваарь хаягийг шинэчилж стандартад нийцүүлэн тэмдэг тэмдэглэгээг сайжруулан ажиллаж байна. | 100% |
| 4.2 | Үйлчлүүлэгч эмнэлгийн дотор болон | | Хэрэгжилтий | Өрхийн эрүүл мэндийн төвийн орчинд | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | гадна орчинд унах, халтирах, бэртэж гэмтэх эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, эрсдэл бууруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх | | н хувь | үйлчлүүлэгч унаж гэмтэж бэртэх эрсдэлийг морсын үнэлгээгээр тогтмол үнэлдэг ба үнэлгээ хийж урьчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж байна.<br>Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах ажлын байрны осол гэмтлээс сэргийлж Форум ланд ХАБ-н мэргэжлийн сургалт, зөвлөх үйлчилгээний төвтэй гэрээний дагуу 2026 онд сургалт зохион байгуулагдан хамрагдлаа. Мөн ажлын байрны эрсдлийн үнэлгээг хийсэн . | |
| 4.3 | Эрүүл мэндийн байгууллагын гадна талбайн орох гарах гарц болон чиглэлийн тэмдэг, тэмдэглэгээг тодорхой, саадгүй байлгах, гадаад орчинд тавигдах аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг тогтмол хангаж ажиллах | ЭМТ | Аюулгүй байдлын гарц, тэмдэг тэмдэглэгээ | Эрүүл мэндийн байгууллагын гадна талбайн орох гарах гарц болон чиглэлийн тэмдэг, тэмдэглэгээг MNS7014:2023 стандартын дагуу хийж байршуулсан.<br>ХБИ -д зорилусан налуу шатыг стандартын дагуу ӨЭМТ-үүд хийж байрлуулсан. | 100% |
| 4.4 | Эмнэлгийн тасаг, нэгжүүдийн байршил, зүг чиг заасан хаяг тэмдэг тэмдэглэгээ, дуугүй хөтөчийг иргэдэд ойлгомжтой уншихад хялбар харагдахуйц байдлаар шинэчлэх | ЭМТ | Хаяг, тэмдэг тэмдэглэгээ<br>Дуугүй хөтөчийг байршуулсан эсэх | MNS 7014:2023 стандартын дагуу байршуулсан.<br>Эмнэлгийн орчинд саадгүй зорчих зорилгоор дуугүй хөтчийг:<br>• Эмнэлгийн үүд хөтчийн хэсэгт<br>• Давхар хоорондын уулзвар шат хооронд<br>• Тасаг нэгж, өрөөний үүдэнд<br>Өнгөөр ялгасан чиглэлийн схемээр гаргах зэрэг зарчмыг баримтлан стандартын дагуу байршуулсан. | 100% |
| | **Нийт хэрэгжилтийн хувь** | | | | **93,6%** |

Тайлан нэгтгэсэн: НЭМТХОДарга [signature] Н.Саранзул

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА М.ӨНӨРСАЙХАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2026 ОНЫ 06 САРЫН 02-НЫ ӨДРИЙН 05 ДУГААР АЛБАН ДААЛГАВРЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | I-IV улирал | Хариуцах албан хаагч |
|---|---|---|---|---|---|---|---|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **ЗОРИЛГО 1.** Эрүүл мэндийн салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 134-р тогтоол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн хууль, журам, стандартын хэрэгжилтийг бүрэн хангах, эрүүл мэндийн удирдах, гүйцэтгэх ажилтны ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгахад зорилго оршино. | | | | | | | |
| **Зорилт 1.** Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлага ёс зүй, дүрэм, журмын хэрэгжилтийг сайжруулах | | | | | | | |
| 1.1 | Байгууллагын хэмжээнд ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг үнэлэх, Эрүүл мэндийн ажилтны ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж, үйлчлүүлэгчтэй зөв боловсон, хүндэтгэлтэй харицах соёлыг хэвшүүлэх | - | Хамруулсан ажилчдын тоо | 0 | 1 | III-IV улирал | Ёс зүйн хороо, ӨЭМТ-үүд |
| | | - | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 0 | 2 | III-IV улирал | Захиргаа, хүний нөөц,ӨЭМТ-үүд |
| 1.2 | Эрүүл мэндийн байгууллага өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах утас, цахим хаягийг олон нийтэд ил тод байршуулах | - | Байршуулсан мэдээллийн тоо | 0 | 1 | III-IV улирал | ЭМТҮЧАБА, Мэдээлэл технологийн алба, ӨЭМТ-үүд |
| | | | Хандалтын, тоо | 0 | 1600 | | |
| 1.3 | Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, ажилтнуудын харилцаа, ёс зүйтэй холбоотой асуудлаар иргэд, байгууллагаас төрийн бүх шатны байгууллагад тавьсан өргөдөл, гомдол, санал хүсэлт, сошиал хуудсанд | - | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн тоо | 0 | - | III-IV улирал | ЭМТҮЧАБА, Мэдээлэл технологийн алба, ӨЭМТ-үүд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гомдол, санал хүсэлт, сошиал хуудсанд байршсан асуудлыг шуурхай шийдвэрлэж, үнэн зөв хариу мэдээлэл өгөх | | | | | | ӨЭМТ-үүд |
| ***Зорилт-2.*** Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, иргэн төвтэй үйлчилгээ үзүүлэх чиглэлээр | | | | | | | |
| 2.1 | Эмнэлгийн туслмаж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр нийт ажилтнуудад мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, эрсдэлийг эрт илрүүлэх, мэдээлэх, буруутгах бус суралцах, тасралтгүй сайжруулах соёлыг төлөвшүүлэх сургалт, идэвхжүүлэх ажлыг зохион байгуулах | ЭМТ | Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо | 0 | 2 | III-IV улирал | ЭМТҮЧАБА, Сургалт хариуцсан менежер, ӨЭМТ-үүд |
| | | | Сургалтанд хамрагдсан хүний тоо | 0 | 120 | III-IV улирал | ЭМТҮЧАБА, Сургалт хариуцсан менежер, ӨЭМТ-үүд |
| 2.2 | Яаралтай тусламжийг харьяалал харгалзахгүйгээр иргэдэд чирэгдэлгүй үзүүлэх | - | Үйлчлүүлэгчийн тоо | - | - | III-IV улирал | Эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн тасаг, ӨЭМТ-үүд |
| 2.3 | "Үйлчлүүлэгчийг дэмжих алба"-г Сувилахын албаны дэргэд байгуулж, чиг үүргийг тодорхойлж, удирдлага арга зүйгээр хангах | ЭМТ | Үйлчлүүлэгчийг дэмжих алба хүний нөөц, тоног төхөөрөмжийн судалгаа гаргах | 0 | 1 | 2026-2027 онд | СХДЭМТ |
| | | | Үйлчлүүлэгчийг дэмжих албыг байгуулах | 0 | 1 | | |
| 2.4 | Эмнэлэг хооронд эмчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох, хүлээлгэн өгөх үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулах, эмнэлгийн тусламжийн тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн эмнэлэг доторх тасаг | - | Шилжүүлсэн үйлчлүүлэгчийн тоо | 0 | 0 | III-IV улирал | Бүх тасаг нэгжүүд, ӨЭМТ-үүд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настанд үзүүлэх тусламжийг чирэгдэлгүй болгох** | | | | | | | |
| 3.1 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настнуудад эмнэлгийн тусламж үйлчилгээг дараалал харгалзахгүй, түргэн шуурхай үзүүлэх орчин нөхцөл, зохион байгуулалтыг бүрдүүлэх | - | Цахим дугаар олголт | - | - | III-IV улирал | СТБТА НЭМТҮА, ӨЭМТ-үүд |
| | | | Эмчилгээ үйлчилгээнд хамрагдсан хүний тоо | 0 | 1000 | | |
| 3.2 | Эмнэлгийн ажилтан, албан хаагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах | - | Зохион байгуулсан сургалтын тоо | - | 90% | III-IV улирал | Сургалт хариуцсан менежер, ӨЭМТ-үүд |
| **Зорилт 4. Эмнэлгийн гадаад, дотоод орчин аюулгүй байдлыг хангах** | | | | | | | |
| 4.1 | Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг хангах, хүртээмжийн хялбаршуулсан үнэлгээ, аюулгүй байдлын үзлэг хийж, илэрсэн зөрчлийг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | - | Хэрэгжилтийн хувь | 0 | 50% | III-IV улирал | ЭМТҮЧАБА, ӨЭМТ-үүд |
| 4.2 | Үйлчлүүлэгч эмнэлгийн дотор болон гадна орчинд унах, халтирах, бэртэж гэмтэх эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, эрсдэл бууруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх | | Хэрэгжилтийн хувь | 0 | 80% | III-IV улирал | ЭМТҮЧАБА, эрсдэл хариуцсан менежер, ӨЭМТ-үүд |
| 4.3 | Эрүүл мэндийн байгууллагын гадна талбайн орох гарах гарц болон чиглэлийн тэмдэг, тэмдэглэгээг тодорхой, саадгүй байлгах, гадаад орчинд тавигдах аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг тогтмол хангаж ажиллах | ЭМТ | Аюулгүй байдлын гарц, тэмдэг тэмдэглэгээ | - | - | III-IV улирал | ХСХТ Аж ахуйн тасаг, ӨЭМТ-үүд |
| 4.4 | Эмнэлгийн тасаг, нэгжүүдийн байршил, зүг чиг заасан хаяг тэмдэг тэмдэглэгээ, дуугүй хөтөчийг иргэдэд ойлгомжтой уншихад хялбар харагдахуйц байдлаар шинэчлэх | ЭМТ | Хаяг, тэмдэг тэмдэглэгээ | - | 1 | III-IV улирал | Мэдээлэл технологийн алба, ӨЭМТ-үүд |
| | | | Дуугүй хөтөчийг байршуулсан эсэх | - | 1 | | |

| |
|---|
| 2026 онд нийт 1 зорилгын хүрээнд 4 зорилт дэвшүүлэн 13 ажил төлөвлөсөн. |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ
ХАРИУЦСАН ОРЛОГЧ ДАРГА /ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ/ Н.САРАНЗУЛ